



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 09 сарын 9 өдөр

Дугаар 297

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн болон 2002 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Жавзандолгор овогтой Пунцагдуламыг АНУ-ын Колорадо Техникийн Их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Элдэвсүрэн овогтой Дамдиндоржийг АНУ-ын Де Врай Их сургуулийн Келлер Удирдлагын сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Энхбат овогтой Энхнаранг Англи улсын Лондон хотын Худалдааны сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. ХБНГУ-ын Ханноверийн Их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр суралцаж буй Тайванхүү овогтой Алтангэрэлийн суралцах хугацааг 0,5 жилээр сунгасугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд

03075

Боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т  
тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл,  
шинжлэх ухааны сайдын 2003 оны 279 дугаар тушаалын  
Э.Дамдиндоржтой холбоотой хэсгийг хүчингүй болсонд  
тооцсугай.

Handwritten notes in Mongolian script, including the word "САЙД" (SAID).

Handwritten signature of A. ЦАНЖИД (A. Tsanjid).

А. ЦАНЖИД